



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2019 оны 12 сарын 03-ны
өдрийн 4541 дугаарт бүртгэв.

ДУНДГОВЬ АЙМГИЙН
АДААЦАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2019 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 09

Тавин

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн
хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “д”, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тус сумын нутаг дэвсгэрт мөрдөх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоож хавсралтаар баталсугай.
2. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг батлагдсан тарифын дагуу аж ахуй нэгж, албан байгууллага, айл өрхүүдэд дагаж мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (Ж.Батхөлөг)-д даалгасугай.
3. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сумын татварын орлогод төвлөрүүлэн, үр дүнг хагас, бүтэн жилээр Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж байхыг сумын Засаг дарга (Ж.Батхөлөг)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаартай тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Г.ТОГТОХБҮРЭН



сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 11-
сарын 11-ны өдрийн 09 дугаар тогтоолын хавсралт

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ

№	Хог хаягдлын нормативын ангилал		Хэмжих нэгж	Нэгжээс авах хураамжийн хэмжээ/төгрөгөөр/
1	Айл өрх	Сумын төвийн өрх	1 өрх	3000
2		Малчин өрх	1 өрх	Жилд 6000
3		Мал бүхий иргэд	50 хүртэл хонин толгой	Жилд 20000
4			51-100 хүртэл хонин толгой	Жилд 30000
5			101-200 хүртэл хонин толгой	Жилд 40000
6			201-ээс дээш хүртэл хонин толгой	Жилд 50000
7	Зочид буудал, амралтын газар, жуулчны бааз		1 ор	Жилд 8000
8	Хүүхдийн цэцэрлэг, ясли		1 хүүхэд	Сард 60
9	Ерөнхий боловсролын сургууль, МСҮТ		1 сурагч	Сард 30
10	Албан байгууллага, /банк, ...		1 ажилтан	Сард 300
11	Соёлын төв		1 суудал	Сард 30
12	Эрүүл мэндийн байгууллага		1 ор	Сард 500
13	Уурын зуух		1 уурын зуух	Сард 300000
14	Худалдаа, үйлчилгээ	Эмийн сан	м2	Сард 150
15		Худалдааны төв, Хүнсний дэлгүүр, зах, супер маркет		Сард 250
16		ШТС		Сард 220
17		Авто засвар, дугуй засвар		Сард 350
18		Үсчин, салон, гоо сайхан, оёдол, халуун ус,	Сард 150	
19	Ресторан, бар, кафе, цайны газар		1 Суудал	Сард 700
20	Уул уурхайн хог хаягдал			Сард 105000
22	Фермерийн аж ахуй	Гахай	1 гахай	Жилд 1000
23	/тэжээвэр амьтан/	Тахиа	1 тахиа	Жилд 800



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2021 оны 01 сарын 07 ны
өдрийн 494 дугаарт бүртгэв.

ДУНДГОВЬ АЙМГИЙН
АДААЦАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 13

Тавин

Малын тоо толгойн албан татварын хувь
хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, Нутаг Дэвсгэрийн Нэгж Түүний Удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 "д", 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар хуралдаанаас ТОГТООХ НЬ :

Нэг. Сумын хэмжээнд малын тоо толгойд ногдуулах албан татварын хувь хэмжээг хавсралтаар баталсугай.

Хоёр. Батлагдсан татварын орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэн ажиллахыг сумын Засаг дарга (Ч.Уранчимэг)-т даалгасугай.

Гурав. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

Дөрөв. Тогтоолын хэрэгжиж эхлэх хугацааг 2021 оны 01 сарын 1-ний өдрөөс эхлэн тогтоосугай.

ДАРГА

Г.ЭНХБАЯР

480119041

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын *2012* оны *12* сарын *18*-ны
өдрийн *15* дугаар тогтоолын хавсралт

№	Малын төрөл	Татварын хэмжээ / 1 толгойд ногдох /
1.	Адуу	1000
2.	Үхэр	1000
3.	Тэмээ	1000
4.	Хонь	300
5.	Ямаа	400